



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөг хянасан:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

Төсвийн ерөнхийлөн захирагч

..... /Б.МӨНХБААТАР/

2021.01.15

Төлөвлөгөө баталсан:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА

Төсвийн Шууд захирагч

..... /Ц.ГАНХҮҮ/

2021.01.15

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж |
|--|---|-------------------------------|--|---|---|-----------------------|----------------------------|
| 1.1. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ | | | | | | | |
| 1.1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт зохицсон байрлал, өндөр, гравиметрийн нэгдсэн сүлжээ байгуулж зураглалын үндэслэлээр хангах | | | | | | | |
| 1.1.1.1 | Монгол улсын өндрийн 1-р ангийн сүлжээ байгуулах | 95 сая төгрөг /Урсгал зардал/ | Өндрийн 1-р ангийн сүлжээний 1 шугам, 55 цэг | 1 полигон 6 шугамтай өндрийн 1-р ангийн сүлжээг 2014-2020 онд байгуулсан. | Эхний хагас жилд: Өндрийн 1-р ангийн 1 шугамыг хэмжих, сүлжээг тэгшитгэн бодох ажлын даалгаврыг баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. Ажлыг эхлүүлсэн байна. Жилийн эцэст: Өндрийн 1-р ангийн сүлжээний 1 шугам байгуулах ажлыг зохих журмын дагуу хүлээн авна. | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 1.1.1.2 | Монгол улсын гравиметрийн сүлжээний 3 цэгт абсолют гравиметрийн хэмжилт хийх бэлтгэл ажлыг хангах | Үйл ажиллагаа | 1. Хамтран ажиллах гэрээний төсөлд авсан санал 2. Гравиметрийн 1-р ангийн сүлжээний 5 цэг | Абсолют гравиметрийн хэмжилт хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, удирдамжийг 2020 онд батлуулсан. Цар тахлын улмаас 2020-2021 онд хийх боломжгүй гэж үзэн хэмжилтийг 2022 оны 6-р сард хийхээр Японы талтай тохирсон. Гравиметрийн 1-р ангийн сүлжээний 5 цэгийн хайгуул, судалгааг 2019-2020 онд хийсэн. | Эхний хагас жилд: Япон улсын Гео-орон зайн мэдээллийн албатай хамтран абсолют гравиметрийн хэмжилт хийх “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг японы талтай зөвшилцөн боловсруулж ГХЯ-наас гэрээний төсөлд санал, зөвшөөрөл авахаар БХБЯ-нд хүргүүлнэ. Гэрээний төсөлд Япон улсын ГХЯ-наас санал, зөвшөөрөл авахаар Япон улсын Гео-орон зайн мэдээллийн албанд хүргүүлнэ. Жилийн эцэс: Гравиметрийн 1-р ангийн сүлжээний 5 цэгийг хамгаалалтад авахаар Дорнод аймгийн Хэрлэн сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Ховд аймгийн Жаргалант сум, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, УБ хотын Баянзүрх дүүргийн Засаг дарга нарт актаар хүлээлгэн өгнө. | III-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 1.1.1.3 | Солбицлын шинэ эринд | Үйл | УБ хотын 5 дүүргийн | 2020 онд УБ хотын 4 дүүрэг | Эхний хагас жилд: УБ хотын | I-II | Геодези, зураг |

| | | | | | | | |
|-------------------------------------|---|---------------|--|---|---|-------------|----------------------------------|
| | шилжихэд шаардлагатай шалгалтын хэмжилт хийх | ажиллагаа | геодезийн сүлжээ, байр зүйн зургийн шалгалт | /Налайх, Багануур, Багахангай, Баянзүрх/-т геодезийн сүлжээ, байр зүйн зургийн шалгалтын хэмжилт хийсэн. | Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүрэгт геодезийн сүлжээ, байр зүйн зургийн шалгалтын хэмжилт хийж, тайлан бичиж үр дүнг байгууллагын удирдлагад танилцуулна. | улирал | зүйн хэлтэс |
| 1.1.1.4 | Солбицлын шинэ эринд шилжих бэлтгэл ажлыг хангах | Үйл ажиллагаа | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | 2020 онд Монгол Улсын GNSS-ийн сүлжээ 335 цэг болон 21 аймгийн төвийн байр зүйн зургийн эрин шалгах, байр зүйн зургийг ITRF2020 эринд шилжүүлэх судалгааны ажил хийгдсэн. | Эхний хагас жилд: Солбицлын шинэ эринд шилжих Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан салбарын холбогдох орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн болон Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хэлэлцүүлж БХБЯ-нд хүргүүлнэ. | I-II улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 1.3. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | | | | | | | |
| 1.3.1 | Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх | | | | | | |
| 1.3.1.1 | Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлэх ТЭЗҮ боловсруулах | Үйл ажиллагаа | ТЭЗҮ | Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний арга зүй, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим систем хийгдсэн. | Эхний хагас жилд: Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлэх ТЭЗҮ боловсруулж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, БХБЯ-нд хүргүүлсэн байна. | I-II улирал | Газар зохион байгуулалтын хэлтэс |
| 1.3.2 | Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | | | | | |
| 1.3.2.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах | Үйл ажиллагаа | 2020 оны улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт | ЗГ-ын 2018 оны 384 дүгээр тогтоолоор "Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө" батлагдсан. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. | Эхний хагас жилд: - Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийг БХБЯ-д хүргүүлсэн байна. - Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар БОАЖЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, ЗТХЯ-дад танилцуулга хийгдсэн байна. Жилийн эцэст: Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн байршлыг /3 байршил/ нарийвчлан тогтоох | I-IV улирал | Газар зохион байгуулалтын хэлтэс |

| | | | | | | | |
|--------------|--|---------------|--|--|--|-------------|----------------------------------|
| | | | | | судалгааг хийж боломжит хувилбаруудыг тогтоосон байна. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн байршлыг нарийвчлан тогтоож, сумын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах ажлыг Аймгийн ГХБХБГ-тай хамтран зохион байгуулж, сонгогдсон байршлуудын хил заагийг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд баталгаажуулсан байна. | | |
| 1.3.3 | Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх | | | | | | |
| 1.3.3.1 | Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | - Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тайланд өгсөн дүгнэлт - Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тайланд өгсөн дүгнэлт | - Булган аймгийн ГЗБЕТ-г боловсруулж байна. - Нийслэлийн ГЗБЕТ-г тодотгон боловсруулж байна. | Эхний хагас жилд: Нийслэлийн ГЗБЕТ-ний тайланг хянаж, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулахад хяналт тавьж, зөвлөгөө өгч алдаа дутагдлыг засварлуулсан байна. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлагатай 8 аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үндэслэл, хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар зөвлөмжийг танилцуулгын хамт хүргүүлнэ. Жилийн эцэст: Булган аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тайланг ирүүлсэн тохиолдолд дүгнэлт өгсөн байна. Булган аймгийн ГЗБЕТ-ний тайлан, тоон мэдээллийг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг эхлүүлсэн байна. | I-IV улирал | Газар зохион байгуулалтын хэлтэс |
| 1.3.3.2 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлын даалгаврын төсөл боловсруулж, холбогдох | Үйл ажиллагаа | Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын даалгаврын жишиг төслийг | Эхний хагас жилд: 3 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлын даалгаврын төсөл боловсруулж, холбогдох аймагт хүргүүлсэн байна. | I улирал | Газар зохион байгуулалтын хэлтэс |

| | | | | | | | |
|---------------------|--|---------------|---|---|---|-------------|----------------------------------|
| | аймагт хүргүүлэх | | ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлын даалгаврын төсөл | боловсруулсан. | | | |
| 1.3.4 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх | | | | | | |
| 1.3.4.1 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | Дүгнэлт гаргаж, батлагдсан төлөвлөгөөний тоо | 24 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. | Эхний хагас жилд: Шинээр нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж буй 15 сумын Газрын даамал, аймгийн ГХБХБГ-т зөвлөмж чиглэл хүргүүлсэн байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих арга зүйн судалгааг хийсэн байна. Санхүүжилтын асуудлыг шийдэх талаар аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төрийн бус байгууллага, Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт үндэслэл, хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар хүсэлтийг танилцуулгын хамт хүргүүлнэ. Жилийн эцэст: Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний арга зүйн төслийг шинэчлэн боловсруулж, 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг хянаж, дүгнэлт гарган гүйцэтгэгчид хүргүүлэх, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг зохион байгуулсан байна. | I-IV улирал | Газар зохион байгуулалтын хэлтэс |
| 1.4. КАДАСТР | | | | | | | |
| 1.4.1 | Газрын суурь үнэлгээний зэрэглэл, Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын хэмжээ, байршил тогтоох | | | | | | |
| 1.4.1.1 | Хот, тосгон, бусад суурины газрын суурь үнэлгээ, суурь үнэлгээний зэрэглэлийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, БХБЯ-нд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Засгийн газрын тогтоолын төсөл | Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол | Эхний хагас жилд: Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулга, хавсралтуудын хамт боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлж, БХБЯ-нд хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Шаардлагатай тохиолдолд тогтоолын төслийг Засгийн газрын тогтоолоор батлахад БХБЯ, Засгийн газрыг холбогдох мэдээллээр хангаж ажилласан | I улирал | Кадастрын хэлтэс |

| | | | | | | | |
|---|--|-----------------|---|---|---|-------------|---|
| | | | | | байна. | | |
| 1.4.1.2 | Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг шинэчлэн батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг БХБЯ-нд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн шинэчилсэн тооллого | Засгийн газрын 2019 оны 323 дугаар тогтоол | Эхний хагас жилд: Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулга, хавсралтуудын хамт боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлж. БХБЯ-нд хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Шаардлагатай тохиолдолд тогтоолын төслийг Засгийн газрын тогтоолоор батлахад БХБЯ, Засгийн газрыг холбогдох мэдээллээр хангаж ажилласан байна. | II улирал | Кадастрын хэлтэс |
| 1.5. ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ | | | | | | | |
| 1.5.1 | Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүрдүүлэгч болон хэрэглэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон зайн өгөгдлийн сангуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах | | | | | | |
| 1.5.1.1 | Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүрдүүлэгч болон хэрэглэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон зайн өгөгдлийн сангуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө боловсруулж батлуулах 1 асуудал хэлэлцүүлэх | Ерөнхий сайдын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 167 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулагдсан, ажиллах удирдамж батлагдсан. | Эхний хагас жилд: Ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулах, хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах асуудлыг ЗГХЭГ-тай хамтран зохион байгуулж, 8 асуудлыг хэлэлцүүлсэн байна. Жилийн эцэст: Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх 1 асуудлын үр дүнг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | I-IV улирал | Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс |
| 1.6. АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ | | | | | | | |
| 1.6.1 | Архивын баримтыг цахимжуулан цахим мэдээллийн сан үүсгэх | | | | | | |
| 1.6.1.1 | Архивын баримтыг цахимжуулах | 23.4 сая төгрөг | Цахимжуулсан 49587 хадгаламжийн нэгжийн баримтыг шинээр хөгжүүлэлт хийсэн архивын программд холбох, Байгууллагын архивын 660 хадгаламжийн нэгжийг цахимжуулан, байгууллагын архивын мэдээллийн санд | Архивын ерөнхий газраас ирүүлсэн 382 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулсан. 2020 оны байдлаар Төрийн архивын нийт баримтын 100 хувь цахимжсан. | Эхний хагас жилд: Цахимжуулсан болон цахимаар хүлээн авсан 1961-2019 оны 25000 хадгаламжийн нэгжийн баримтыг шинээр хөгжүүлэлт хийсэн архивын программд холбоно. Байгууллагын архивт хүлээн авсан 260 хадгаламжийн нэгжийн цахимжуулан, байгууллагын архивын мэдээллийн санд оруулж холбоно. Жилийн эцэст: Цахимжуулсан болон цахимаар хүлээн авсан 1961-2019 оны 24587 хадгаламжийн нэгжийн баримтыг шинээр хөгжүүлэлт хийсэн | I-IV улирал | Архив, мэдээллийн төв, Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар |

| | | | | | | | |
|----------------------------|--|-----------------------------------|--|--|--|-------------|-------------------------|
| | | | оруулах | | архивын программд холбоно. Байгууллагын архивт хүлээн авсан 400 хадгаламжийн нэгжийн цахимжуулан, байгууллагын архивын мэдээллийн санд оруулж холбоно. | | |
| 1.6.2 | Төрийн архивын улсын үзлэгт хамрагдах | | | | | | |
| 1.6.2.1 | “Төрийн архивын улсын үзлэг”-т хамрагдах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэн 2 сан хөмрөгийн баримтын тооллого хийсэн. | Эхний хагас жилд: АЕГ-аас ирүүлэх “Төрийн архивын улсын үзлэг зохион байгуулах” ажлын удирдамжийн дагуу үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, уг төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангана. “Төрийн архивын улсын үзлэг”-ийн урьдчилсан үзлэг хийнэ. Жилийн эцэст: Улсын үзлэгийн комисст шалгуулж дүгнүүлнэ. | I-IV улирал | Архив, мэдээллийн төв |
| 1.7. ХОТ БАЙГУУЛАЛТ | | | | | | | |
| 1.7.1.1 | Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын захиалагчийн техникийн хяналт хийх | Захиалагчийн хяналтын зардлын дүн | Захиалагчийн хяналтын дүгнэлт | Төслийн дундын тайланг дүгнэж үр дүнг БХБЯ-нд хүргүүлсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Эцсийн тайланг хүлээн авч үр дүнг БХБЯ-нд хүргүүлсэн байна. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.2 | Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | Хэрэгжилтэд хийсэн дүгнэлт | Төслийн дундын тайланг дүгнэж үр дүнг БХБЯ-нд хүргүүлсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Төслийн ажилтай холбоотой үйл ажиллагаанд оролцож ажиллах, хэрэгжилтэд хяналт тавина. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.3 | Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүсүүдийн хөгжлийн төслийг боловсруулах | Үйл ажиллагаа | Бүсүүдийн хөгжлийн төслийн санал, ажлын даалгаврын төслийн санал | “Үндэсний хөгжлийн цогц бодлого” боловсруулж байна. | Жилийн эцэст: Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан Баруун бүсийн тулгуур төв, Улиастай хот, Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хот, Дархан хот, Зүүн бүсийн тулгуур төв-, Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөни хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг батлуулсан байна. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.4 | Бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийх (Дархан, Сэлэнгэ, Орхон, | Үйл ажиллагаа | Хэрэгжилтэд хийсэн дүгнэлт, санал | Дорнод аймгийн Их сургуулийн хотхоны ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байна. | Жилийн эцэст: Хийгдэж буй төсөлтэй танилцаж санал, зөвлөмж боловсруулж БХБЯ-нд хүргүүлнэ. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |

| | | | | | | | |
|----------|--|-----------------------------------|-------------------------------|---|---|-------------|-------------------------|
| | Багануур, Ховд, Завхан) | | | | | | |
| 1.7.1.5 | Орхоны хөндийд шинэ хотын суурьшлийн бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах | Захиалагчийн хяналтын зардлын дүн | Зургийн даалгавар | Шинээр хийгдэх | Жилийн эцэст: Шинэ хот байгуулахад шаардлагатай ТЭЗҮ боловсруулахад шаардагдах зургийн даалгаврын төсөл боловсруулж БХБЯ-нд хүргүүлнэ. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.6 | “Шинэ зуунмод”, “Майдар” хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгаа хийж, шийдвэрлүүлэх | Үйл ажиллагаа | Судалгаа, шийдвэр | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 14-ны өдөр “Хот байгуулах тухай” 55 дугаар тогтоолоор баталсан. | Жилийн эцэст: Төслийн ажилтай холбоотой үйл ажиллагаанд оролцож ажиллах, санал өгнө. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.7 | Хөшигийн хөндийг даган хөгжих “Шинэ Зуунмод” хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах | Захиалагчийн хяналтын зардлын дүн | Захиалагчийн хяналтын дүгнэлт | Төслийн эхлэлийн тайланг дүгнэж үр дүнг БХБЯ-нд хүргүүлсэн. | Жилийн эцэст: Гэрээгээр заасан ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.8 | Хөшигийн хөндийг даган “Майдар” шинэ дагуул хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах | Захиалагчийн хяналтын зардлын дүн | Захиалагчийн хяналтын дүгнэлт | - Олон улсын нисэх онгоц, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий нэгдсэн логикийн ТЭЗҮ, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах сонгон шалгаруулалт зарлагдсан. Олон улсын нисэх онгоц, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий нэгдсэн логикийн инженерийн дэд бүтцийн эх үүсвэрийг тодорхойлох, ажлын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалт зарлагдсан. | Жилийн эцэст: Гэрээгээр заасан ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.9 | Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх | Үйл ажиллагаа | Тайланд өгсөн дүгнэлт | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “ТГТ” ХХК гүйцэтгэж байна. | Жилийн эцэст: Гэрээгээр заасан ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | I-II улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.10 | Алтанбулаг чөлөөт | Үйл | Тайланд өгсөн | Алтанбулаг хилийн | Жилийн эцэст: Гэрээгээр заасан | I-IV | Хот |

| | | | | | | | |
|----------|---|---------------|-----------------------|--|---|-------------|-------------------------|
| | бүсийн хөгжлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх | ажиллагаа | дүгнэлт | боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2019 онд боловсруулсан. | ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | улирал | байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.11 | Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх | Үйл ажиллагаа | Тайланд өгсөн дүгнэлт | - | Жилийн эцэст: Гэрээгээр заасан ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.12 | “Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”-ийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах | Үйл ажиллагаа | Санал | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага батлагдсан. | Жилийн эцэст: БХБЯ-аас өгсөн чиглэлийн дагуу үйл ажиллагаанд оролцох, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах, санал зөвлөмж өгнө. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.13 | Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах | Үйл ажиллагаа | Санал | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний судалгааны ажилтай танилцаж хэлэлцүүлсэн. | Жилийн эцэст: БХБЯ-аас өгсөн чиглэлийн дагуу үйл ажиллагаанд оролцох, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах, санал зөвлөмж өгнө. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.14 | Хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоог боловсруулах | Үйл ажиллагаа | Судалгаа | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу аймгийн төвүүд болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлаар холбогдох тооцоо, судалгааг хийн 2020 оны 03 сарын 05-ны өдрийн 1/637 дугаартай албан бичгээр УИХ-ын Байнгын хороо, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яаманд санал хүргүүлсэн. | - | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.15 | Дархан, Эрдэнэт зэрэг улсын зэрэглэлтэй хот байгуулах болон аймгийн төвүүдийг хот болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай судалгаа, | Үйл ажиллагаа | Судалгаа | | Жилийн эцэст: Хангай бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ТЭЗҮ боловсруулахаар бэлтгэл ажлыг хангана. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |

| | | | | | | | |
|--------------------------------------|--|-----------------------------------|---|---|--|---------------|-----------------------------------|
| | тооцоог боловсруулах | | | | | | |
| 1.7.1.16 | АХБ-ны ТТ-ны “Ногоон хот төлөвлөлт” төслийн хүрээнд Булган аймагт хэрэгжүүлэх хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд “ногоон” хөгжлийн төлөвлөлтийн зарчмаар төлөвлөх ажилд захиалагчийн хяналт хийх | Захиалагчийн хяналтын зардлын дүн | Захиалагчийн хяналтын дүгнэлт | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Сонголт Дизайн” ХХК гүйцэтгэж байна. | Гэрээгээр заасан ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | I-II улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.7.1.17 | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төвийн хэсгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд захиалгчийн хяналт хийх | Захиалагчийн хяналтын зардлын дүн | Захиалагчийн хяналтын дүгнэлт | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил сонгон шалгаруулалт зарлагдсан. | Гэрээгээр заасан ажлын хуваарийн дагуу үнэлэлт, дүгнэлт гаргаж, үр дүнг БХБЯ-нд хүргүүлнэ. | I-IV улирал | Хот байгуулалтын хэлтэс |
| 1.8. ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТР | | | | | | | |
| 1.8.1 | 1.8.1. Хот байгуулалтын кадастрын цахим системийг хөгжүүлэх | | | | | | |
| 1.8.1.1 | Газрын кадастрын мэдээллийн сан цахим систем болон Хур системээс аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системийн программ хангамжийн хөгжүүлэлт хийх | - | Газрын кадастрын болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээллийг бүртгэх программ | - | Программ хөгжүүлэлтийг хийж дууссан байна. | II-III улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.1.2 | Нийгмийн дэд бүтэц, орон сууц, хог хаягдлын цэг, оршуулгын газар, ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн эх үүсвэр болон технологийн барилгын мэдээллийг цахим системээр бүртгэх программ хангамжийн хөгжүүлэлт хийх | - | Нийгмийн дэд бүтэц, орон сууц, хог хаягдлын цэг, оршуулгын газар, ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн эх үүсвэр болон технологийн барилгын мэдээллийг бүртгэх программ | 2020 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн. | Программ хөгжүүлэлтийг хийж дууссан байна. | I-II улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.1.3 | Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн | - | Барилгын мэдээлэл бүртгэх программ | - | Программ хөгжүүлэлтийг хийж дууссан байна. | I-II улирал | Хот байгуулалтын |

| | | | | | | | |
|--------------|--|---|--|--|--|--------------|-----------------------------------|
| | газрын “Хот байгуулалтын менежментийн систем”-г хот байгуулалтын кадастрын “Урбан менежер систем”-тэй холбох программ хангамжийн хөгжүүлэлт хийх | | | | | | кадастрын хэлтэс |
| 1.8.1.4 | Үндэсний статистикийн хорооны орон сууцны мэдээллийн сангаас веб үйлчилгээ авах программ хангамжийн хөгжүүлэлт хийх | - | Улсын хэмжээний орон сууцны тооллогын үр дүнг нэгтгэх | - | Программ хөгжүүлэлтийг хийж дууссан байна. | I-III улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.2 | Хот байгуулалтын кадастрын цахим системд мэдээлэл бүртгэх | | | | | | |
| 1.8.2.1 | 21 аймгийн 309 сумын барилга байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | - | 21 аймгийн 309 сумын барилга байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх | 21 аймгийн төвийн сумын 7954 барилгын мэдээллийг 2020 онд бүртгэсэн. | 21 аймгийн 309 сумын барилгын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна. | I-IV улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.2.2 | 21 аймгийн төвийн сумын 2010 оноос хойших орон сууцны мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх | - | Орон сууцны барилгын үнэ, талбайн мэдээлэл бүртгэх | - | 21 аймгийн төвийн сумын орон сууцны барилгын мэдээлэл бүртгэсэн байна. | I-IV улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.2.3 | 21 аймгийн хэмжээнд оршуулгын газар, хог хаягдлын төвлөрсөн цэгийн мэдээллийг бүрдүүлэх, хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх | | 21 аймгийн хэмжээнд оршуулгын газар, хог хаягдлын төвлөрсөн цэгийн мэдээлэл бүртгэх | - | 21 аймгийн оршуулгын газар, хог хаягдлын мэдээллийг бүртгэсэн байна. | II-IV улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.2.4 | Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бүртгэх | - | 132 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бүртгэх | - | ГЗБХТ-н цахим системд төлөвлөгөөг бүртгэсэн байна. | I-II улирал | Хот байгуулалтын кадастрын хэлтэс |
| 1.8.2.5 | ХБК-ийн мэдээллийн санд 21 аймгийн төвийн сумын инженерийн дэд | - | 7 төрлийн мэдээлэл бүртгэх | 2020 онд 21 төвийн сумын инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон | ХБК-ийн мэдээллийн санд 7 төрлийн мэдээллийг бүртгэсэн байна. | I-IV улирал | Хот байгуулалтын кадастрын |

| | | | | | | | |
|--|---|------------------------------|---|--|--|--------------|--|
| | бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн мэдээллийг бүртгэх | | | байгууламжийн мэдээллийг бүртгэх ажлыг эхлүүлсэн. | | | хэлтэс |
| 1.9. ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГА | | | | | | | |
| 1.9.1 | Бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах | | | | | | |
| 1.9.1.1 | Хуулиудын төслийг Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай ажлыг зохион байгуулах | Урсгал зардал, үйл ажиллагаа | 8 хууль /Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн төсөл | Хуулийн төслийг БХБЯ-нд хүргүүлсэн, үзэл баримтлал батлагдсан. | Эхний хагас жилд: Хуулийн төсөлтэй холбоотой мэдээ, судалгааг хийх, нэгтгэн хянаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Хуулийн төсөлтэй холбоотой мэдээ, судалгааг хийх, нэгтгэн хянаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | I-IV улирал | Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Суурь судалгаа, мониторингийн хэлтэс, Газар зохион байгуулалтын хэлтэс, Кадастрын хэлтэс, Геодези, зураг зүйн хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, Хот байгуулалтын хэлтэс |
| 1.9.1.2 | Хаягжуулалтын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал | БХБ-ын Сайдын 2020 оны 11 сард баталсан Хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөөгөөнд Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 онд боловсруулах заалт орсон. | Эхний хагас жилд: Хаягжуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулгыг бэлэн болгож БХБЯ-нд хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулахад шаардлагатай мэдээ, мэдээлэл гаргаж өгч хамтран ажиллана. | I-III улирал | Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Кадастрын хэлтэс, Геодези, зураг зүйн хэлтэс |
| 1.9.1.3 | Үндэсний орон зайн | Үйл | 2 баримт бичиг | Дэлхийн банкны Зөвлөх | Эхний хагас жилд: Орон зайн | I-II | Орон зайн |

| | | | | | | | |
|--------------|---|-----------------------|---|--|---|-------------|---------------------------------------|
| | өгөгдлийн дэд бүтцийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БХБЯ-нд хүргүүлэх | ажиллагаа | | баг, Монгол Улсын орон зайн мэдээллийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн судалгааны ажил, НҮБ-ын Зөвлөхүүдийн хороотой хамтран Монгол Улсын Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц: Нийгэм, эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ (103 хуудас), Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг бэхжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо (27 талбар), Үндэсний Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн бодлогын орчны шинжилгээ (47 хуудас), Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (152 хуудас), Монгол Улс: Орон зайн мэдээллээр Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээг дэмжих нь (32 хуудас), Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн стратеги (26 хуудас), Орон зайн мэдээллээр Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих нь (14 хуудас) зэрэг нийт 7 төрлийн баримт бичгүүдийг боловсруулсан. | мэдээллээр Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих нь - Sustainable Economic Growth For Mongolia Supported by Geospatial Information” зэрэг 2 баримт бичгийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэвлэлийн эх бэлтгэх, хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Засгийн газрын тогтоолын төслийг БХБЯ руу хүргүүлж, баримт бичгүүдийг хэлэлцэх, албажуулахад шаардлагатай мэдээ, материалаар БХБЯ-ыг хангаж, НҮБ-ын зөвлөхүүд болон Дэлхийн банктай тухай бүр хамтран ажилласан байна. | улирал | мэдээлэл, технологийн хэлтэс |
| 1.9.2 | Норм, дүрэм боловсруулах | | | | | | |
| 1.9.2.1 | Норм, дүрэм шинэчлэн боловсруулж, батлуулах | Барилга байгууламжийн | Барилгын норм ба дүрэм-5 Барилгын дүрэм-1 | 2020 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгч 4 дүрэм | Эхний хагас жилд: <i>ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх</i> - “1:10 000, 1:25 000, 1:50 000, | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс, Кадастрын |

| | | | | | | | |
|---------|--|--|---|---|--|--------------------|-------------------------------|
| | | норм, норматив ын сангийн хөрөнгө | | боловсруулж БХТ-д хүргүүлсэн. Шүүмж, хянан тохиолдуулга хийгдэж байна. 2021 оны норм, нормчлолын сангийн хөрөнгөөр 2 дүрэм шинэчлэн боловсруулахаар санал хүргүүлсэн. | 1:100 000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил” БД - “Хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)- ын технологиор Монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” /БНБД 14-101-08/ БНБД <i>Төсвийн тооцоо, ажлын даалгавар боловсруулах, БХБЯ-нд хүргүүлэх</i> - “1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил” /БНБД 11-106- 08/ БНБД - "Авто зам болон төмөр замын геодезийн ажил" /БНБД 11-114- 14/ БНБД Жилийн эцэст: <i>ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх</i> - “Кадастрын зураглалын ажил” /БНБД 11-11-16/ - “Барилгын геодезийн ажил” БНБД <i>Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх</i> - “1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил” /БНБД 11-106- 08/ - "Авто зам болон төмөр замын геодезийн ажил" /БНБД 11-114- 14/ | | хэлтэс |
| 1.9.2.2 | Норм, дүрэм шинээр боловсруулж, БХБЯ-нд батлуулахаар хүргүүлэх | Барилга, байгуулам жийн норм, норматив ын сангийн хөрөнгө | Барилгын норм ба дүрэм-3 Барилгын дүрэм-4 | 2019-2020 онд 2 дүрмийн төслийг БХБЯ-ны ШУТТЗ- ийн хурлаар хэлэлцүүлсэн, 2 дүрмийн төслийг БХБЯ- ны ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн, 2 дүрмийн төслийг боловсруулж шүүмж, хянан тохиолдуулга хийгдэж байна. 2021 оны норм, | Эхний хагас жилд: <i>2 сайдын хамтарсан тушаалаар батлуулах</i> - “Геодези, зураг зүйн ажлын аюулгүй ажиллагаа” БД <i>ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх</i> - “Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр том, дунд масштабын байр зүйн зураглал хийх” БД - “Геодези, зураг зүйн ажлын техникийн тайлан, төсөл бичих заавар” БД | I-II, IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |

| | | | | | | | |
|--------------|---|--|------------------------------|---|--|-------------|--|
| | | | | нормчлолын сангийн хөрөнгөөр 3 дүрэм шинээр боловсруулахаар санал хүргүүлсэн. | <ul style="list-style-type: none"> - “GNSS-ийн байнгын ажиллагаатай станцыг ажиллуулах, хэвийн үйл ажиллагааг хангах” БД - “Газрын зураг, атласын редакци, зохиолт, хэвлэлийн эх бэлтгэх, хяналт хийх” БД <p><i>Төсвийн тооцоо, ажлын даалгавар боловсруулах, БХБЯ-нд хүргүүлэх</i></p> <ul style="list-style-type: none"> - “Агаар, сансрын зургийн боловсруулалтын ажил” БД - “Хот суурин газрын өндөржилт төлөвлөлт хийх геодезийн ажил” БНБД <p>Жилийн эцэст: <i>Дүрмийн төслийг хүлээн авч, санал өгөх, ГЗЗ-н ОТБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх</i></p> <ul style="list-style-type: none"> - “Агаар, сансрын зургийн боловсруулалтын ажил” БД - “Хот суурин газрын өндөржилт төлөвлөлт хийх геодезийн ажил” БНБД | | |
| 1.9.3 | Стандарт боловсруулах | | | | | | |
| 1.9.3.1 | Үндэсний стандартын төсөл боловсруулах, батлуулах | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгө Урсгал төсөв 13.6 сая /9 стандарт - 414 хуудас*32 857/. | Үндэсний стандарт-21: | 2019-2020 онд 3 стандартын төслийг боловсруулж батлуулахаар 2020 онд СХЗГ-т хүргүүлсэн. | <p>Эхний хагас жилд: <i>СХЗГ-ын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх, батлуулах:</i></p> <ul style="list-style-type: none"> ✓ Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5283:2014 ✓ Геодези, зураг зүй. Нэр томъёоны тодорхойлолт MNS 3951:1986 <p><i>Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> ✓ ISO19119-Үйлчилгээ ✓ ISO19157-Өгөгдлийн чанар ✓ ISO19131-Бүтээгдэхүүний өгөгдлийн техникийн үзүүлэлт ✓ Орон зайн мэдээллийн суурь 8 өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлага /UML/- | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс |

| | | | | | | | |
|--------------|---|---------------|---------|---|---|-------------|---|
| | | | | | ийн стандартууд Жилийн эцэст: СХЗГ-ын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулах: ✓ ISO19119-Үйлчилгээ ✓ ISO19157-Өгөгдлийн чанар ✓ ISO19131-Бүтээгдэхүүний өгөгдлийн техникийн үзүүлэлт ✓ Орон зайн мэдээллийн суурь 8 өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлага /UML/-ийн стандартууд | | |
| 1.9.4 | Журам боловсруулах | | | | | | |
| 1.9.4.1 | Засгийн газраар батлуулах журмын төслийг боловсруулах, санал авах, хурлаар хэлэлцүүлэх, хүргүүлэх | Үйл ажиллагаа | 7 журам | Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол “Газар зүйн нэрийг хамгаалах, хадгалах, ашиглах” журмыг боловсруулан 2019 оны 12 сард БХБЯ-нд хүргүүлсэн. | Эхний хагас жилд: Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлж, БХБЯ-нд хүргүүлж, шаардлагатай тооцоо, судалгааг тухай БХБЯ-нд хүргүүлсэн байна. Үүнд: 1. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам 2. “Газар зүйн нэрийн зургийг хадгалах, ашиглах” журам 3. “Газар зохион байгуулалт хийх журам”-ыг батлуулахад шаардагдах тооцоо, судалгааг хийх 4. “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам” 5. “Газрын нөхөн сэргээлт хийх журам” Жилийн эцэст: Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлж, БХБЯ-нд хүргүүлж, шаардлагатай тооцоо, судалгааг тухай БХБЯ-нд хүргүүлсэн байна. Үүнд: 1. “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” 2. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлангийн маягыг | I-IV улирал | Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Газар зохион байгуулалтын хэлтэс, Суурь, судалгаа, мониторингийн хэлтэс, Кадастрын хэлтэс Геодези, зураг зүйн хэлтэс |

| | | | | | | | |
|--------------|--|---------------|---------------------|---|--|-------------|---|
| | | | | | шинэчлэн боловсруулах | | |
| 1.9.4.2 | Сайдаар батлуулах журмыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэх | Үйл ажиллагаа | 1 журам | БХБС-ын 2015 оны 246 тоот тушаал, БХБС-ын 2019 оны 191 тоот тушаал | Эхний хагас жилд: Журмын төслийг боловсруулж, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, БХБЯ-нд хүргүүлсэн байна. | I улирал | Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар |
| 1.9.4.3 | Салбарын хэм хэмжээний актыг боловсруулж, албажуулан, хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 8 хэм хэмжээний акт | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын удирдлагын нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. ГХГЗЗГ /хуучин нэрээр/-ын даргын 2015 оны А/134 тоот тушаал Засгийн газрын 2003 оны 28, 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан. | 1. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам 2. Нийгэм, эдийн засгийн мэдээллийн цахим системийг ажиллуулах журам"-ын төслийг боловсруулах 3. "Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам"-ын төслийг боловсруулах 4. "Шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн боловсруулах 5. "Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг шинэчлэн боловсруулах /2017 А-253/ 6. Геопорталаар дамжуулан байгууллага, хэрэглэгчдэд үйлчлэх "НЭЭЛТТЭЙ ГАЗРЫН ЗУРАГ" үйлчилгээний журам боловсруулах 7. Геоплатформоор дамжуулан төрийн байгууллага хооронд "НЭГ ГАЗРЫН ЗУРАГ" үйлчилгээг солилцох журам боловсруулах 8. Салбарын төрийн архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, баримт хүлээн авах журам | I-IV улирал | Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Газар зохион байгуулалтын хэлтэс, Кадастрын хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, Архив мэдээллийн төв |
| 1.9.5 | Заавар, аргачлал, загвар, маягт, эмхэтгэл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах | | | | | | |
| 1.9.5.1 | Заавар боловсруулах | Үйл ажиллагаа | 3 заавар | ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/40 тоот тушаал, ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/287, А/170 дугаар тушаал Leica MS60/TS60 маркийн | Эхний хагас жилд: 3 зааврыг боловсруулж, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. Үүнд: 1. Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, | I-II улирал | Кадастрын хэлтэс |

| | | | | | | | |
|---------|-------------------------------------|---------------|------------|--|---|-------------|---|
| | | | | электрон тахеометр багажинд шалгалт, тохируулга хийх аргачлалыг газрын даргаар батлуулсан. | хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын заавар"-д нэмэлт өөрчлөлт оруулах 2. "Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар"-ыг шинэчлэн боловсруулах 3. "Газрын биржийн цахим системийг ажиллуулах заавар"-ыг шинэчлэх | | |
| 1.9.5.2 | Аргачлал, гарын авлага боловсруулах | Үйл ажиллагаа | 7 аргачлал | 2 аргачлалын төслийг боловсруулсан. | Эхний хагас жилд: Аргачлалын төсөлд аймаг, нийслэлийн газрын албад, холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэсэн байна. 1. Trimble маркийн электрон тахеометр шалгах, тохируулга хийх аргачлал 2. Leica маркийн электрон тахеометр шалгах, тохируулга хийх аргачлал 3. Геоплатформд төвлөрүүлсэн мэдээллийн үйлчилгээний түгээх хураамж тооцох аргачлал 4. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах газарт газарзүйн мэдээллийн систем ашиглан газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргачлал Жилийн эцэст: Аргачлалын төслийг шинэчлэн боловсруулж, орон тооны бус мэргэжлийн зөвлөл, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. 1. "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторинг хийх аргачлал"-ын төсөл 2. "Газрын нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын төсөл | I-IV улирал | Суурь, судалгаа, мониторингийн хэлтэс, Кадастрын хэлтэс, Архив, мэдээллийн төв, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, Хот байгуулалтын хэлтэс |

| | | | | | | | | |
|--------------|---|---------------|--|--|--|---|---------------|---|
| | | | | | | 3. Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлалыг шинэчлэн боловсруулах | | |
| 1.9.5.3 | Загвар, маягт боловсруулах | Үйл ажиллагаа | Дуудлага худалдаагаар газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэх гэрээний загвар | Засгийн газрын 2003 оны 204 дугаар тогтоол, ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/170 тоот тушаал | | Эхний хагас жилд: Дуудлага худалдаагаар газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэх гэрээний загварыг боловсруулж газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | I улирал | Кадастрын хэлтэс |
| 1.9.5.4 | Гарын авлага боловсруулах | Үйл ажиллагаа | 2 гарын авлага | - | | Эхний хагас жилд: Геодезийн хэмжил зүйн лабораторийн чанарын гарын авлагыг боловсруулж ДДЗХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна. Жилийн эцэст: Архивын программын сургалтад шаардлагатай гарын авлагыг боловсруулж ДДЗХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна. | I, III улирал | Архив, мэдээллийн төв |
| 1.9.6 | Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын Сайдаар батлуулах | | | | | | | |
| 1.9.6.1 | Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох зорилт, арга хэмжээг тусгах | Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төсөл боловсрогдсон | | Эхний хагас жилд: Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг эрхэлсэн Сайдаар батлуулах ажлыг зохион байгуулна. | I улирал | Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар |

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа I-IV улирал/ | Хариуцах нэгж |
|--|---|---------------|---|---|--|----------------------|---|
| 2.1. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ | | | | | | | |
| 2.1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт зохицсон байрлал, өндрийн нэгдсэн сүлжээ байгуулж зураглалын үндэслэлээр хангах | | | | | | | |
| 2.1.1.1 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг хөтлөх | Үйл ажиллагаа | GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээ, өндрийн сүлжээний - 3000 цэг, тэмдэгт | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2020 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | Эхний хагас жилд: Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим мэдээллийн сангийн 1000 цэг, тэмдэгтийн хувийн хэрэг, мэдээллийг шинэчлэн хөтөлнө. Жилийн эцэст: Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим мэдээллийн сангийн 2000 цэг, тэмдэгтийн хувийн | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс, Архив, мэдээллийн төв, Орон зайн мэдээлэл технологийн |

| | | | | | | | |
|---------|---|---------------|--|--|--|-------------|----------------------------|
| | | | | | хэрэг, мэдээллийг шинэчлэн хөтөлнө. | | Хэлтэс |
| 2.1.1.2 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Баян-Өлгий аймаг 45 цэг тэмдэгт Өмнөговь аймаг 18 цэг тэмдэгт | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх” журмыг баталсан. | Эхний хагас жилд: Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг нөхөн сэргээх ажлын даалгаврыг баталж, Баян-Өлгий аймаг, Өмнөговь аймгийн ГХБХБГ-т хүргүүлнэ. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг нөхөн сэргээхэд Баян-Өлгий аймаг, Өмнөговь аймгийн ГХБХБГ-тай хамтран ажиллана. Жилийн эцэст: Нөхөн сэргээсэн цэг, тэмдэгтийг сумын Засаг даргад актаар хүлээлгэн өгч, мэдээллийг геодезийн цэг, тэмдэгтийн цахим санд оруулна. 21 аймаг, нийслэлийн геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын тайланг хүлээн авч, мэдээллийг геодезийн цэг, тэмдэгтийн цахим санд оруулна. | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 2.1.1.3 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | 43 байнгын ажиллагаатай станц Бодит агшны хяналтын хэмжилт - 4 | 2013-2017 онд Улсын төсвөөр 38, УБ хотын төсвөөр 5 станц суурилуулсан. 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын өгөгдлийг хадгалах, дамжуулах, нэгтгэн бодох, дүн шинжилгээ хийх тогтолцоо бүрдүүлсэн. | Эхний хагас жилд: GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангана. 43 станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 2 удаагийн шалгалтын хэмжилтээр хяналт тавина. Жилийн эцэст: GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангана. 43 станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 2 удаагийн шалгалтын хэмжилтээр хяналт тавина. | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 2.1.1.4 | GNSS-ийн сүлжээний тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн хэвийн ажиллагааг хангах туршилт, судалгааны ажил хийх | Үйл ажиллагаа | Систем -1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг хөгжүүлж, | Эхний хагас жилд: GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн програм хангамжийг шинэчлэх судалгаа, туршилт хийнэ. Жилийн эцэст: GNSS-ийн байнгын | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |

| | | | | | | | |
|--------------|---|---------------|---|--|---|-------------|----------------------------|
| | | | | хэрэглээнд нэвтрүүлсэн. 2020 оны 12 дугаар сард ажиллагаа доголдсон. | ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн хэвийн ажиллагааг хангах санал боловсруулж байгууллагын удирдлагад танилцуулна. | | |
| 2.1.1.5 | GNSS-ийн сүлжээний хэмжилтийн өгөгдлийг тэгшитгэн бодох | Үйл ажиллагаа | Өндрийн 1-р ангийн сүлжээний 115 цэг | Өндрийн 1-р ангийн сүлжээний 60 цэг дээр 2020 онд GNSS-ийн хэмжилт хийж урьдчилсан бодолтыг гүйцэтгэсэн. | Эхний хагас жилд: Өндрийн 1-р ангийн сүлжээний 60 цэг дээр 2020 онд хийсэн GNSS-ийн сүлжээний хэмжилтийн өгөгдлийг тэгшитгэн бодож, жагсаалтыг батлуулах, цэг, тэмдэгтийн цахим санд оруулж хэрэглээнд нэвтрүүлнэ. Жилийн эцэст: Өндрийн 1-р ангийн сүлжээний 55 цэг дээр 2021 онд хийх GNSS-ийн сүлжээний хэмжилтийн өгөгдлийг тэгшитгэн бодно. | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 2.1.1.6 | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжид 10 нэмэлт эрх худалдан авах | Үйл ажиллагаа | Удирдлагын програм хангамжид нэмэлт эрх-10 | 2020 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжийг шинэчилж, 35 станцыг холбон хэвийн ажиллагааг хангасан. | Эхний хагас жилд: GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжид нэмэлт эрх худалдан авах ажлын даалгаврыг боловсруулж, батлуулна. Програм хангамжийн эрхийг худалдан авна. Жилийн эцэст: Удирдлагын програм хангамжид 8 станцыг холбож, 43 станцыг удирдана. | I улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |
| 2.1.2 | Жижиг, дунд, том масштабын /газар дээрх болон доорх биетийн/ байр зүйн тоон зургаар хангах | | | | | | |
| 2.1.2.1 | Том масштабын байр зүйн тоон зургийн шинэчлэлтийг хөтлөх | Үйл ажиллагаа | 21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн шинэчлэлт | Шинэчлэлт өөрчлөлтийг 192.168.10.37 сервер дээр хөтөлж байна. 21 аймаг, нийслэлийн 2020 оны эхний хагас жилд шинэчлэлт баяжуулалт хийсэн тайланг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч зохих журмын дагуу АМТ-д хүлээлгэн өгсөн. | Эхний хагас жилд: 21 аймаг, нийслэлийн 2020 оны сүүлийн хагас жилийн байдлаар шинэчлэлт хийсэн тайланг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүлээн авч зохих журмын дагуу АМТ-д хүлээлгэн өгсөн байна. 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн шинэчлэлтийг нэгтгэн орон зайн мэдээллийн системд оруулна. Жилийн эцэст: 21 аймаг, нийслэлийн 2021 оны эхний хагас жилийн байдлаар шинэчлэлт хийсэн тайланг 2021 оны 07 дугаар сарын | I-IV улирал | Геодези, зураг зүйн хэлтэс |

| | | | | | | | |
|---------|--|---------------|---|--|---|-------------|---|
| | | | | | 01-ний өдрийн дотор хүлээн авч зохих журмын дагуу АМТ-д хүлээлгэн өгсөн байна. 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн мэдээллийн санг нэгтгэн орон зайн мэдээллийн системд оруулна. Байр зүйн зургийн мэдээллийн систем байгуулах судалгаа хийж, санал боловсруулан байгууллагын удирдлагад танилцуулна. | | |
